



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Нэр бүхий арилжааны банкуудад харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Банкны тухай хуулийн 6.2.7 дахь заалт, Монголбанкны хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны хоёрдогч зах зээлд зөвхөн Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах зорилгоор энэхүү тогтоолын хавсралтад нэр дурьдсан арилжааны банкуудад харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгосонтой холбогдуулан хууль, тогтоомжоор хүлээсэн дараахь үүргийг чанд биелүүлж ажиллахыг нийт тусгай зөвшөөрөл бүхий арилжааны банкуудад үүрэг болгосугай:

1/ Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх дотоод журам боловсруулж 2013 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэх. Уг журамд дараахь зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

а/ брокерийн болон дилерийн үйл ажиллагаа эрхлэх;

б/ дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

в/ харилцагчдыг эрсдлээс хамгаалах үйл ажиллагаа;

г/ харилцагчид, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх тухай.

2/ Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах

000083

зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж байх;

4/ Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөн ажиллах.

3. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг зохицуулах журмыг Сангийн яам, Монголбанктай хамтран өөрчлөн найруулсны үндсэн дээр шинэчлэн батлуулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар /Т.Доржханд/, Монголбанкны Валют, эдийн засгийн газар /Д.Дэлгэрсайхан/-т үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  ДБАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 72 дугаар тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ХОЁРДОГЧ ЗАХЗЭЭЛ ДЭЭР ХАРИЛЦАГЧИЙН
НЭРИЙН ӨМНӨӨС ТҮҮНИЙ ДААЛГАВРААР ГҮЙЦЭТГЭХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
БАНКУУД

№	Банкны нэр	Гүйцэтгэх удирдлага
1.	Улаанбаатар хотын банк	А.Энхмэнд
2.	Худалдаа Хөгжлийн банк	Б.Мэдрээ
3.	Чингис хаан банк	Л.Ариунаа
4.	Хаан банк	Н.Като
5.	Голомт банк	Ж.Финиган
6.	Төрийн банк	Ж.Отгонбилэг
7.	Хадгаламж банк	С.Сүхболд
8.	Капитрон банк	П.Мөнхсайхан
9.	Капитал банк	А.Ариунболд
10.	Хас банк	М.Болд
11.	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	Б.Баярсайхан